

Хөдөлмөрийн зах зээл хариуцсан мэргэжилтэн, Б Амина  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
3.1. Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна.							
1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан.	Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулсан байна. /1 танилцуулга /	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн 2025 оны тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход хөдөлмөрийн зах зээл, ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, дэлгэрэнгүй судалгаа хийсэн. Уг шинжилгээ, судалгаанд тулгуурлан тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хөгжлийн баримт бичгүүдэд тусгасан. Тухайлбал, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, 2025 оны нэгдсэн төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн макро эдийн засгийн танилцуулгуудад тусгаж, бодлогын чиглэл тодорхойлоход ашигласан. Хавсралт: 1 файл		
2	Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан.	Эдийн засгийн 2025 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулах хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн Засгийн газрын хуралдаан, УИХ-аар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж ажилласан. Хавсралт: 1 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3	Монгол Улсын тухайн	Тооцоо,	Монгол Улсын	Макро эдийн	Монгол Улсын 2025 оны	7-р сар,	100%

	<p>жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	<p>төсөөллийн танилцуулгын тоо</p>	<p>2024 оны төсвийн тухай хууль батлагдсан.</p>	<p>засгийн нөхцөл байдал, 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/</p>	<p>төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээллийг боловсруулах ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтээр тооцоо, төсөөлөл хийж танилцуулгад тусган ажилласан. Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дахин өргөн барьсантай холбоотойгоор холбогдох танилцуулга, шипид мэдээллийг шинэчлэн боловсруулж тусгаад байна.</p> <p>Хавсралт: 2 файл</p>	<p>8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
--	--	------------------------------------	---	---	--	---	--

3.2. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.

4	<p>Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна.</p>	<p>Дүн шинжилгээний тоо</p>	<p>Өмнөх онуудын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.</p>	<p>2024 оны түвшинд дүн шинжилгээ хийж танилцуулсан байна. /хийсэн тухай бүрийн танилцуулга/</p>	<p>Макро эдийн засгийн улирал тутмын танилцуулга боловсруулах хүрээнд хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлт, цалингийн үзүүлэлтүүд, ажилгүйдэл, хөдөлмөрийн бүтээмж, цалин, ажиллах хүчний оролцооны түвшинд дүн шинжилгээ хийж, 2024 оны II ба III улирлын</p>	<p>7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	100%
---	--	-----------------------------	---	--	---	--	------

					танилцуулгад тусгасан. Хавсралт: 2 файл		
5	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана.	Хөгжүүлсэн загварын тоо	Мэдээллийн дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн.	Загвар хөгжүүлсэн байна /1 загвар/	"МУ-ын эдийн засагт шууд татварын хувь хэмжээг 1 хувиар бууруулахад үзүүлэх нөлөөллийг Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн Загвар (CGE Model) хөгжүүлж тооцооллыг хийсэн. Суурь тоон өгөгдөл болох 2018 оны Нийгмийн тооцооллын матриц дахь өрхүүдийн орлогыг ӨНЭЗС-аас тооцон 5 бүлэгт хувааж задлан шинжилсэн. Түүнчлэн БНСУ, Евроазийн эдийн засгийн холбоо, БНХАУ-тай байгуулах Чөлөөт худалдааны хэлэлцээр болон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулахад шаардлагатай эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг олон улсын худалдааны GТAP загвар ашиглан тооцож үр дүнг боловсруулсан."	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
6	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр мэдээллээр	Мэдээллийн тоо /Тоо/	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн.	Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/	Тус газраас олон нийтэд нээлттэй мэдээллэдэг Макро эдийн засгийн сарын мэдээнд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	100%

	хангана.				суурилсан тооцоо шинжилгээг тухай бүр тайланд оруулж байна. Түүнчлэн тус тайлангийн яамны удирдлагад зориулсан Макро эдийн засгийн сарын мэдээний хувилбарт НӨАТ-ын мэдээллийн сангийн аж ахуйн нэгжийн борлуулалтын мэдээллийг сар бүр оруулж ажиллаж байна. Хавсралт: 5 файл	12-р сар	
7	Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана.	Мэдээллийн тоо /Тоо/	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн.	Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/	Power BI ашиглан өдөр тутмын зах зээлийн мэдээллүүдийг тухай бүрд нь шинэчлэн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Хавсралт: 3 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
8	Монгол Улсын эдийн засгийн эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болон төсвийн тухай хуулийн танилцуулгад тусгана.	Эдийн засгийн эрсдэлийг тодорхойлсон танилцуулгын тоо	Эдийн засгийн болзошгүй эрсдэлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн.	Болзошгүй эрсдэлийн судалгааг боловсруулж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна./2 танилцуулга/	Монгол Улсын эдийн засгийн болзошгүй эрсдэлийг судалж 1/ эрчим хүчний тасалдал, 2/ зуд, ган, мал амьтны өвчин, 3/ экспортын түүхий эдийн үнийн бууралт, 4/ геополитикийн тогтворгүй байдал, 5/ нийлүүлэлтийн тасалдлын хүрээнд тодорхойлж 2025 оны жилийн төлөвлөгөө,	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					2025 оны төсвийн тухай хуулийн танилцуулгад Эрсдэлийн хэсэгт тусгасан болно. Хавсралт: 2 файл		
9	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	Тайланд ашигласан тоо	-	Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/	НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгээд байна. Түүнчлэн Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн улирал, жилийн мэдээллээр дата бааз үүсгэсэн. Мөн засаглал, нийгэм, эдийн засаг, хөгжил, дэд бүтцийн 93 олон улсын индексээрх Монгол Улсын үнэлгээ, эрэмбийн цагийн цувааны дата бааз үүсгээд байна. Гааль, И-баримтын датаг сар бүрд тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирал, сар тутмын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ханган ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
10	Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг боловсруулна.	Судалгааны тоо	Судалгаанд шаардлагатай тоон мэдээллийг цуглуулсан.	Судалгаа боловсруулсан байна. /1 судалгаа/	Монгол улсын макро эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгаанд хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшний урт хугацааны хандлагад дүн шинжилгээ хийж, тайланг боловсруулсан. Хавсралт: 1 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
3.3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ.							
11	Эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайлан бэлтгэж удирдлагад танилцуулна.	Тайлангийн тоо	Тайланд шаардлагатай судалгааны тоон мэдээллийг цуглуулсан.	Тайлан боловсруулсан байна. /1 тайлан/	Макро эдийн засгийн богино хугацааны идэвхжилийн тайланд шаардлагатай судалгааны тоон мэдээллийг цуглуулж, хөдөлмөрийн зах зээлийн динамик, ажил эрхлэлт, ажилгүйдлийн трендийг тодорхойлж, дүн шинжилгээ хийж, богино хугацааны төлөвийг дүгнэж боловсруулсан. Хавсралт: 1 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
12	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны	Тооцоо, төсөөллийн	Монгол Улсын 2024 оны төсвийн	Макро эдийн засгийн нөхцөл	Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн дунд	7-р сар, 8-р сар,	100%

	төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	танилцуулгын тоо	тухай хууль батлагдсан.	байдал, 2024-2027 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/	хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн 2024 оны гүйцэтгэл, 2025-2027 оны төсөөллийг тооцож, танилцуулга бэлтгэсэн. 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан. 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр "Монгол Улсын Нэгдсэн Төсвийн 2025 оны Төсвийн Хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны Төсвийн Төсөөллийн тухай" хууль батлагдсан. Хавсралт: 2 файл	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	---	------------------	-------------------------	---	--	--	--

3.4. Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

13	Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг Өв уламжлалын сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс"-т тулгуурлан судалж шаардлагатай тоо, мэдээллийг цуглуулан сан үүсгэж дүн	Өгөгдлийн сангийн тоо	-	Өгөгдлийн сан үүсгэсэн байх /1 файл/	Өв уламжлалын сангийн "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс"-ийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг цуглуулан нэгтгэж, дүн шинжилгээ хийж дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэн,	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
----	--	-----------------------	---	--------------------------------------	---	--	------

	шинжилгээ хийнэ.				удирдлагуудад танилцуулж ажилласан. Хавсралт: 2 файл		
14	Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр санал боловсруулж танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулна.	Танилцуулгын тоо	-	Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/	Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс, Дэлхийн өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Бертельсманны шилжилтийн индекс зэрэг олон улсын голлох индексүүдийн үзүүлэлтүүдийн дата мэдээллийг нэгтгэн боловсруулж, эрэмбэ байрыг ахиулах боломжийг судлан, санал бэлтгэж танилцуулгад тусган удирдлагад танилцуулав. Үнэлгээг сайжруулах чиглэлээр бодлогын санал, зөвлөмжүүдийг тодорхойлж, хөгжлийн төлөвлөгөө, төсвийн бодлогын баримт бичигт тусгасан. Хавсралт: 1 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
15	Эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр олон нийтэд үнэн, зөв	Олон нийтэд хүргэсэн мэдээллийн тоо	-	Олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна. /1 нийтлэл/	Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадвар, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг хэмжиж	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар,	100%

128

мэдээлэл ажиллана.	хүргэж				<p>буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн голлох индексүүдийн аргачлал, хэмжиж буй үзүүлэлтүүд, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж яамны цахим хаяг болон веб хуудаст тогтмол байршуулж байна. Үүний хүрээнд 2024 оны эхний хагаст Өрсөлдөх чадварын индекс, Авлигын төсөөллийн индекс, Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн 2024 оны үнэлгээ, Монгол Улсын авч буй оноо, эрэмбийн талаар мэдээ мэдээллийг тус яамны веб хуудасны "Эдийн засгийн тойм блог" цэст байршуулав. Түүнчлэн тус газраас боловсруулж, олон нийтэд нээлттэй байршуулж, бодлогын шийдвэр гаргагч байгууллагуудад тараадаг Макро эдийн засгийн 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1-3 дугаар улирлын тайланд "Олон улсад зарлагдсан индексүүд"-ийн дэд бүлгийг бэлтгэн</p>	11-р сар, 12-р сар	
-----------------------	--------	--	--	--	---	-----------------------	--

					<p>оруулсан. Тайланд          Авлигын төсөөллийн          индекс, Ардчиллын          индекс, Дэлхийн          өрсөлдөх чадварын          тайлан, Бертелсманны          Шилжилтийн индекс, Өв          уламжлалын сангийн          Эдийн засгийн эрх          чөлөөт байдлын индекс,          Засаглалын          үзүүлэлтүүд, Фрэйзэр          институтын Эдийн          засгийн эрх чөлөөт          байдлын индексүүдийн          Монгол Улсын үнэлгээ          болон олон улсын чиг          хандлагад шинжилгээ          хийж оруулаад байна.          Хавсралт: 4 файл</p>		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							

1	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх	Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдсан байх	-	Мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдсан байна.	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Тухайлбал, "GTAP олон улсын худалдааны CGE загвар"-ын цахим сургалт болон Олон Улсын Валютын Сангийн "Макро эдийн засгийн диагностик", "Макро эдийн засгийн төсөөлөл" сэдэвт цахим сургалтууд, ОУВС-гийн Кавказ, Төв Ази, Монголын Бүс Нутгийн Чадамж Дээшлүүлэх Төвөөс зохион байгуулсан "Макро эдийн засгийн шинжилгээ/Санхүүгийн програмчлал ба бодлого" сургалтад биеэр хамрагдсан.  Хавсралт: 1 файл	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Үндэсний Монгол бичгийн анхан шатны сургалтад хамрагдсан байх	Үндэсний Монгол бичгийн анхан шатны сургалтад хамрагдсан байх	-	Анхан шатны сургалтад хамрагдсан байна.	Үндэсний Монгол бичгийн анхан шатны сургалтад хамрагдаж байсан.	6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	100%
3	Байгууллагаас зохион байгуулдаг албан хаагчдад мэдээлэл түгээх, санал, солилцох зорилготой "Мэдээллийн цаг"-т оролцсон байх	албан хаагчдад мэдээлэл түгээх, санал, солилцох зорилготой "Мэдээллийн цаг"-т оролцсон байх	-	"Мэдээллийн цаг"-т оролцсон байна	8 дугаар сарын 23-ны өдрийн "Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал", 9 дүгээр сарын 20-ны өдрийн "Захиргааны хэм хэмжээний акт, түүний хэрэгжилт", 11 дүгээр сарын 7-ны өдрийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөөг программд бүртгэх, биелэлт гаргах, хууль тогтоомжийн биелэлт оруулах талаар", 11 дүгээр сарын 22-ны өдрийн "Ус усны нөөц ирээдүй", "Эрчим хүч хэмнэх энгийн боломжууд" зэрэг мэдээллийн цагт оролцсон.	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөдөлмөрийн зах зээл хариуцсан мэргэжилтэн, Б Амина /.....*Б. Амина*...../

Огноо: .....*12.18.2024*.....

*12/18*